



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 04 дугаар сарын 20

Дугаар А/09

Чингис хот

Аудитын тайлан
баталгаажуулах тухай


“Төрийн аудитын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, МУЕА-ын “Эрх шилжүүлэх тухай” 2025 оны А/175 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын 3 дах заалтыг үндэслэн **ТУШААХ нь**:

1. “Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн санхүүгийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Хэнтий аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг аудитор (Б.Ариунаа)-д үүрэг болгосугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 15 -ны өдрийн дотор тус тус Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэнтий аймгийн Засаг дарга (Д.Аюурбунь)д зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитор (Б.Ариунаа)-д даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ж.ГАНБААТАР



Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын ²⁰²⁶ оны дүгээр сарын ²⁰ -ны өдрийн ^{А/09} дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Хэнтий аймгийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар хүргүүлсэн албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Аудитын код	Төлбөрийн актын дугаар	Дүн /төгрөг/
1	Хэнтий аймгийн Засаг дарга	ХЭА-2026/001/НА-СТА-ТЕЗ	298-A2370448/ХЭА-2026/001/НА-СТА-ТЕЗ	
	ДҮН			-

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2026/001/НА-СТА-ТЕЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: Oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Б.Ариунаа Утас: 99195208 Х.Баярбаатар Утас: 99058696 Б.Хуланхатан Утас: 99008827 Н.Хэрлэнбаяр Утас: 89051308 Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан.....	6
2.1 аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
3. АУДИТЫН ТАЙЛАН	10
3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	10
3.1.1 Аудит хийсэн үндэслэл.....	10
3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ.....	10
3.1.3 Аудитын арга зүй	10
3.1.4 Материаллаг байдлын түвшин.....	10
3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ	10
3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж	11
3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн.....	11
3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР	11
3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	11
3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	11
3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	12
3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	12
4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	13
4.2 АВЛАГА	15
4.3 УРЬДЧИЛГАА.....	17
4.4 БАРАА МАТЕРИАЛ	18
4.5 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	20
4.6 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20
4.7 ӨР ТӨЛБӨР	21
4.8 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	22
4.9 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	23
4.10 ӨМНӨХ ОНЫ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ.....	24
4. 11 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	24
5. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	25
5.1 АЛБАН ШААРДЛАГА.....	25
5.2 ҮАГ-Т ӨГӨХ САНАЛ	25
6 АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	26
6.1 Алдааны нэгтгэл	26
6.2 Зөрчлийн нэгтгэл	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СДОА	Сум дундын ойн анги
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.04.20 № 563
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдалд болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Бор-Өндөр сумын Хүүхдийн дөрөвдүгээр цэцэрлэг, Батширээт тохижилт ОНӨААТҮГ шинээр байгуулагдсан байна.

Аудитаар нийт 53 санхүүгийн тайланд дүгнэлт өгснөөс Цэнхэрмандал сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд “Сөрөг”, Галшар, Баянхутаг, Баян-Адарга, Баян-Овоо, Баянмөнх, Батширээт, Бор-Өндөр, Биндэр, Дархан, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Өмнөдэлгэр, Жаргалтхаан, Хэрлэн сумд, Өлзийт, Гурванбаян тосгоны захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, аймгийн ИТХ, Баян-Адарга, Баян-Овоо, Баянмөнх, Батширээт, Бор-Өндөр, Галшар, Жаргалтхаан, Мөрөн, Цэнхэрмандал, Хэрлэн сумдын ЗДТГ, Гурванбаян, Өлзийт, Тахилгат тосгодын ЗАА, Өндөрхаан хот тохижилт ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн нь дүгнэлт гарсан байгууллагуудын 64.1 хувийг эзэлж байна.

Тайлант онд ТЕЗ-ийн харьяа орон нутгийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 21,785.0 сая төгрөгийн 163 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж,

54.7 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 1,049.5 сая төгрөгийн зөрчилд 32 албан шаардлага хүргүүлж, 877.4 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өгч, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 3, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй 1, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан 1, нийт 5 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлж, гэмт хэргийн шинжтэй 1 асуудлыг Прокурорын байгууллагад шилжүүлсэн байна.

Илэрсэн зөрчлийг өмнөх онтой харьцуулахад тооны хувьд 2.8 дахин буюу 36 зөрчлөөр, мөнгөн дүнгийн хувьд 972.5 сая төгрөг буюу 2.0 дахин өссөн байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 718.3 сая төгрөгийн 6 алдаа илэрснийг аудитын явцад залруулж, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд 1 албан шаардлага өглөө.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Аравдугаар хуралдааны 01 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилтийг “Үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		55,506,433.70	53,638,219.75
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	37,327,093.99	33,039,366.56
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	7,464,608.47	7,975,775.51
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	952,144.38	1,624,432.27
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	9,315,525.86	10,416,057.91
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	243,936.00	379,462.50
7	1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	203,125.00	203,125.00
8	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		199,550,415.87	251,023,343.93
9	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	199,550,415.87	251,023,343.93
10	1.2.2.02 Биет хөрөнгө		180,134,757.21	237,407,371.81
11	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	19,415,658.66	13,615,972.12
12	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		255,056,849.57	304,661,563.69
13	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		42,137,643.02	83,408,686.30
14	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		29,716,592.07	71,220,885.91
15	2.1.1.02 Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	221,804.58	163,137.18
16	2.1.1.03 Өглөг		9,353,331.53	6,043,034.84
17	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	18а, 18б	20,141,455.96	65,014,713.89
18	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		12,421,050.96	12,187,800.38
19	2.1.2.02 Урт хугацаат зээл	20а, 20б	12,421,050.96	12,187,800.38
20	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		212,919,206.54	221,252,877.39
21	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		212,919,206.54	221,252,877.39
22	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		32,579,626.32	32,664,058.92
23	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/		2,022,060.10	2,066,153.37
24	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		162,912,967.50	171,178,264.86
25	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		15,404,552.62	15,344,400.25
26	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		255,056,849.57	304,661,563.69

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		158,887,383.48	130,215,850.29
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		42,750,415.16	51,269,255.26
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		31,926,740.74	38,210,567.18
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		28,199,349.54	32,305,181.54
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(1,008,998.09)	1,417,950.16
6	1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар		4,736,389.29	7,323,335.80
7	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		2,755,264.29	3,100,896.77
8	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		8,068,410.13	9,957,791.31
9	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	110,002,807.20	78,946,595.03
10	1.1.1.04.2 Хөрөнгийн орлого		232,082.39	255,199.01
11	1.1.1.04.3 Тусламжийн орлого		-	3,665,888.19
12	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		6,134,161.12	-
13	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	84,538,054.67	101,486,468.08
14	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		84,531,054.67	95,209,138.77
15	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		81,801,564.96	92,852,631.70
16	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		22,656,131.88	28,009,980.44
17	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,735,911.11	4,467,346.35
18	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		18,159,549.75	19,433,317.48
19	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		2,241,033.70	2,826,270.98
20	1.1.2.01.1.05 Нормативт зардал		848,499.35	154,595.13
21	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		2,214,041.54	2,366,817.26
22	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		743,571.24	816,882.10
23	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		10,372,889.91	12,108,147.03
24	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		21,829,936.49	22,669,274.92
25	1.1.2.01.3 ТАТААС		399,012.00	1,002,011.50
26	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,330,477.72	1,354,495.58
27	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		7,000.00	6,277,329.30
28	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		74,349,328.81	28,729,382.21
29	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		50,435,818.88	20,404,046.55
30	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(50,435,818.88)	(20,404,046.55)
31	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		23,913,509.93	8,325,335.65

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,088,087.90		190,088,087.90
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,091,851.77)		(1,091,851.77)
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	188,996,236.13		188,996,236.13
4	1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(2,388.98)		(2,388.98)
5	1.1.1.1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	43,398.00		43,398.00
6	1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт	(31,548.54)		(31,548.54)
7	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	23,913,509.93		23,913,509.93
8	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	212,919,206.54		212,919,206.54
9	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	212,919,206.54		212,919,206.54
10	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(127,488.77)		(127,488.77)
11	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	212,791,717.77		212,791,717.77
12	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(9,838.95)		(9,838.95)
13	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	34,119.18		34,119.18
14	1.4 Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	24,075.00		24,075.00
15	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	87,468.74		87,468.74
16	1.7 Тайлант үеийн үр дүн	8,325,335.65		8,325,335.65
17	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	221,252,877.39		221,252,877.39

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	131,828,371.99	122,465,681.25
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	42,750,415.16	51,269,255.26
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	31,926,740.74	38,210,567.18
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,008,998.09)	(1,417,950.16)
5	1.1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар	4,736,389.29	7,323,335.80
6	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	2,755,264.29	3,100,896.77
7	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	8,068,410.13	9,957,791.31
8	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,536,286.62	1,656,739.14
9	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	2,381,914.95	3,211,595.60
10	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,150,208.56	5,089,456.57
11	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,270,309.20	71,196,425.99
12	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	23,346,014.61	22,934,658.26
13	1.1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	232,082.39	255,199.01
14	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	4,623,132.23
15	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	56,692,212.20	43,383,436.50
16	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,807,647.63	-
17	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	85,301,341.15	90,736,767.92
18	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	85,301,341.15	90,736,767.92
19	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,526,492.95	89,373,212.92
20	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,289,946.87	31,697,943.43
21	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,666,618.55	4,322,293.63
22	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,442,350.39	21,057,419.71
23	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	6,817,654.92	5,549,003.48
24	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	839,795.26	58,173.23
25	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	2,357,485.93	2,499,797.25
26	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	749,225.83	760,215.32
27	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,151,847.33	15,420,386.85
28	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	13,211,568.88	8,007,980.01
29	1.1.1.2.01.3 ТАТААС	399,012.00	2,011.50
30	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,375,836.21	1,361,543.51
31	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	46,527,030.83	31,728,913.33
32	1.1.2.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	338.53	125.06
33	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	35,404,126.69	33,540,404.06
34	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,404,126.69	33,540,404.06
35	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	35,404,126.69	33,540,404.06
36	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(35,403,788.15)	(33,540,279.00)
37	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,182,380.47	2,417,694.36
38	1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	71,528.42	58,667.40
39	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(1,253,908.89)	(2,476,361.76)
40	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	9,869,333.79	(4,287,727.43)
41	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,457,760.21	37,327,093.99
42	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	37,327,093.99	33,039,366.56

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

3.1.1 Аудит хийсэн үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

3.1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС, санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн эсэхэд дүгнэлт гаргаж, үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэсэн.

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар нэмэлт тодруулгуудад АОУС, Төрийн аудитын MNS 6817-4:2020 Санхүүгийн аудитын тулгуур зарчимд заасны дагуу аудитын горим, сорилыг төлөвлөж, хэрэгжүүлсэн.

Төрийн аудитын байгууллага нь аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл сан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

3.1.3 Аудитын арга зүй

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын горим сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж үнэлгээ өгөв.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл, мөн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж болон бусад эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн нийцэл зэрэг асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайланд тусгасан.

3.1.4 Материаллаг байдлын түвшин

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл сан, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн тул материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үе шатанд аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 158,911.3 сая төгрөгийн 1.5 хувь буюу 2,383.7 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд материаллаг өөрчлөлт гараагүй тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Аймгийн ЗДТГ-ын СТСХ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх заалтын дагуу Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, хуулийн хугацаанд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын тооцоогоор баталгаажуулсан өр төлбөр, авлага, ажил гүйлгээний давхардсан 248.8 сая төгрөгийг санхүүгийн байдлын тайланд, 163.7 сая төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд, 164.5 сая төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тус тус цэвэрлэх бичилт хийсэн;
- Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвийн 49 байгууллага, 45 төсөл, сан, 22 орон нутгийн өмчит, 23 аймаг, сумын ерөнхий орлогын данс, 29 бусад данс, улсын төсвийн 65 боловсрол, 24 эрүүл мэнд, 27 соёлын байгууллага нийт 284 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

3.2.1 Тайланг илэрхийлсэн мөнгөн нэгж

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлжээ.

3.2.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны “finperform.mof.gov.mn” нэвтрэлтийн нэгдсэн системээр нэгтгэн гаргасан бөгөөд үндсэн тайлан, байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар тодруулга гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

3.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

3.3.1 Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн 304,661.6 сая төгрөг болж, өмнөх оноос 19.4 хувиар нэмэгдсэн байна.

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Эргэлтийн хөрөнгийн дүн	55,506.40	53,638.22	(1,868.18)	18%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	199,550.40	251,023.34	51,472.94	82%
Нийт хөрөнгийн дүн	255,056.80	304,661.56	49,604.76	100%
Нийт өр төлбөр	42,137.60	83,408.69	41,271.09	27%
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	212,919.20	221,252.87	8,333.67	73%
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн	255,056.80	304,661.56	49,604.76	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49,604.7 сая төгрөгөөр өсөхөд Хэнтий-Ус ХХК 44,786.1 сая төгрөг, Өндөрхаан хот тохижилт ОНӨААТҮГ 3,243.0 сая төгрөг, Баян-Адарга сумын ЗДТГ 2,411.5 сая төгрөг, Дадал сумын ЗДТГ 1,804.9 сая төгрөг, Хэрлэн сумын ЗДТГ 1,271.2 сая төгрөг, аймгийн ерөнхий орлогын данс 1,527.2 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сан 1,662.5 сая төгрөг, Бор-Өндөр сумын ерөнхий орлогын данс 1,133.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.3.2 Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 8,325.3 сая төгрөгийн эерэг үзүүлэлттэй гарсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үр дүн 3,546.6 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүн 3,597.7 сая төгрөг, төрийн сангийн үйл ажиллагааны үр

дүн 884.0 сая төгрөг, төсөл, сангийн үйл ажиллагааны үр дүн 297.0 сая төгрөгийн эерэг /орлого нь зардлаасаа их/ үр дүнгийн үзүүлэлттэй байна.

3.3.3 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Засаг даргын 2025 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаар Засгийн газрын хувь оролцоо 8,333.7 сая төгрөгөөр өсөж, тайлант үеийн үр дүн 15,588.2 сая төгрөгөөр буурсан байна.

3.3.4 Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Засаг даргын 2025 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд үйл ажиллагааны мөнгөн орлого 122,465.7 сая төгрөг, зарлага 90,736.8 сая төгрөг болж, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 31,728.9 сая төгрөгийн эерэг, хөрөнгө оруулалтын мөнгөн орлого 0.1 сая төгрөг, зарлага 33,540.4 сая төгрөг болж, хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ 33,540.3 сая төгрөгийн сөрөг, санхүүгийн үйл ажиллагааны зардал 2,476.4 сая төгрөгийн сөрөг үзүүлэлттэй илэрхийлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

1. Санхүүгийн тайланг харьяа ТТЗ-ийн тайланд зөрүүтэй нэгтгэсэн, санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд орлогын ангиллыг буруу бүртгэсэн, санхүүжилтийг тусгалгүй орхигдуулсан нийт 9,991.6 сая төгрөгийн 65 алдаа илэрснийг сум, байгууллагаар дурдвал:

- Баян-Адарга сумын Засаг дарга 4,978.4 сая төгрөг,
- Баянхутаг сумын Засаг дарга 397.6 сая төгрөг,
- Мөрөн сумын Засаг дарга 95.3 сая төгрөг,
- Цэнхэрмандал сумын Засаг дарга 331.7 сая төгрөг,
- Биндэр сумын ЗДТГ 289.8 сая төгрөг,
- Дэлгэрхаан сумын ЗДТГ 62.6 сая төгрөг,
- Гурванбаян тосгоны ОНХС 150.4 сая төгрөг,
- Дадал сумын ОНХС 107.0 сая төгрөг,
- Мөрөн сумын ОНХС 114.3 сая төгрөг,
- Норовлин сумын ОНХС 107.6 сая төгрөг,
- Цэнхэрмандал сумын ОНХС 706.8 сая төгрөг,
- Аймгийн ОНХС 400.1 сая төгрөг,
- Халамжийн сан /Орон нутаг/ 179.6 сая төгрөг,
- Оюуны шим ӨЭМТ 567.7 сая төгрөг,
- Хэрлэндом ӨЭМТ 459.9 сая төгрөг,
- Хэнтий -Ус ХХК 466.7 сая төгрөг

2. Нийт 173.8 сая төгрөгийн 11 зөрчил илэрснээс 13.1 сая төгрөгийн зөрчилд 5 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Галшар сумын ИТХ-ын 1, Мөрөн сумын ЗДТГ-ын 2, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй аймгийн ИТХ 1 албан тушаалтанд, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан Цэнхэрмандал сумын Засаг дарга;

Нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримт, холбогдох стандарт, заавар журмын дагуу хөтлөөгүй 160.7 сая төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлснийг байгууллагаар харуулбал:

- Галшар сумын ИТХ 2.7 сая төгрөг,
- Баян-Овоо сумын ЗДТГ 6.2 сая төгрөг,
- Биндэр сумын ЗДТГ,
- Бор-Өндөр сумын ЗДТГ 4.4 сая төгрөг,
- Цэнхэрмандал сумын ЗДТГ 5.9 сая төгрөг,
- Батширээт сум тохижилт ОНӨААТҮГ 141.5 сая төгрөг тус тус байна.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 33,039.4 сая төгрөг болж, өмнөх оноос 4,287.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касс байгаа бэлэн мөнгө	3.30	0.94	(2.36)	0%
Банкинд байгаа бэлэн мөнгө	37,133.50	32,694.97	(4,438.53)	99%
Замд яваа мөнгөн хөрөнгө	190.30	343.46	153.16	1%
Дүн	37,327.10	33,039.37	(4,287.73)	100%
Үүнээс: байгууллагын төрлөөр				
ОНӨҮГ	1,259.30	1,131.49	(127.81)	3%
Төрийн сан	21,584.23	22,038.61	454.38	67%
Төсөвт байгууллага	21.79	31.71	9.92	0%
Төсөл, сан	14,461.78	9,837.56	(4,624.22)	30%
Дүн	37,327.10	33,039.37	(4,287.73)	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,287.7 сая төгрөгөөр буурахад орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 127.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, төсөл, сангийн 4,624.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Банканд байгаа мөнгөн хөрөнгийн 31,564.5 сая төгрөг буюу 96.5 хувь нь төрийн сан, 1,130.5 сая төгрөг буюу 3.5 хувь нь арилжааны банканд байршиж байна. Арилжааны банканд байгаа мөнгөн хөрөнгө нь 21 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үлдэгдэл байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн 343.5 сая төгрөг нь аймаг, сумын төсвийн орлого байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 22,038.6 сая төгрөг болж, өмнөх оноос 454.4 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна.

Хүснэгт №3. Сумдын ерөнхий орлогын дансны үлдэгдэл, сумаар /сая төгрөгөөр/

Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Хэнтий аймаг	6,545.14	8,102.31	1,557.17	37%
Батноров сум	518.21	587.35	69.14	3%
Батширээт сум	1,857.43	1,350.00	(507.43)	6%
Баян-Адарга сум	380.41	320.54	(59.86)	1%
Баянмөнх сум	574.66	540.01	(34.65)	2%
Баян-Овоо сум	531.44	452.71	(78.73)	2%
Баянхутаг сум	273.67	333.94	60.27	2%
Биндэр сум	450.26	343.85	(106.42)	2%
Бор-Өндөр сум	1,244.36	2,377.54	1,133.19	11%
Бэрх тосгон	418.00	314.18	(103.81)	1%
Галшар сум	349.60	419.89	70.29	2%
Гурванбаян тосгон	122.30	49.50	(72.80)	0%
Дадал сум	604.02	474.37	(129.65)	2%
Дархан сум	422.87	574.81	151.94	3%
Дэлгэрхаан сум	880.35	481.08	(399.27)	2%
Жаргалтхаан сум	141.89	278.43	136.53	1%
Мөрөн сум	533.67	456.88	(76.79)	2%
Норовлин сум	362.89	283.65	(79.24)	1%
Өлзийт тосгон	415.10	487.36	72.26	2%
Өмнөдэлгэр сум	492.99	538.65	45.65	2%
Хэрлэн сум	4,035.43	2,977.96	(1,057.47)	14%
Хэрлэнбаян-Улаан тосгон	243.83	116.06	(127.77)	1%
Цэнхэрмандал сум	185.70	177.54	(8.16)	1%
Дүн	21,584.23	22,038.61	454.38	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн үлдэгдлийн 13,457.8 сая төгрөг буюу 61.1 хувь нь аймгийн болон Бор-Өндөр, Хэрлэн сумдын ерөнхий орлогын дансны үлдэгдэл эзэлж байна.

Аймаг, сумдын ерөнхий орлогын дансны үлдэгдэл өсөхөд татварын болон татварын бус орлого 13,114.8 сая төгрөгөөр давж биелсэн, төсвийн байгууллагуудын зарцуулагдаагүй үлдэгдэл 16,172.6 сая төгрөг төвлөрүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсөл, сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 5,407.8 сая төгрөг буюу 55.0 хувийг сумдын орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл, 2,262.6 сая төгрөг буюу 23.0 хувийг сумдын хоршоо хөгжүүлэх сан /хуучнаар сум хөгжүүлэх сан /-ийн үлдэгдэл, 1,784.1 сая төгрөг буюу 18.1 хувийг хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгө, мал хамгаалах сангийн үлдэгдэл, 225.0 сая төгрөг буюу 2.3 хувийг байгаль хамгаалах сангийн үлдэгдэл эзэлж байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4. Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл, сумдаар

/сая төгрөгөөр/

№	Сум, тосгоны нэр	Орон нутгийн хөгжлийн сан			Сум хөгжүүлэх сан		
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	Аймаг	239.42	867.53	628.11	-	-	-
2	Батноров	207.21	229.04	21.83	116.03	41.85	(74.18)
3	Батширээт	49.72	115.77	66.05	63.33	118.05	54.72
4	Баян-Адарга	187.71	166.04	(21.67)	84.42	209.50	125.08
5	Баянмөнх	134.30	155.25	20.95	242.01	257.82	15.82
6	Баян-Овоо	48.11	209.94	161.82	177.45	156.55	(20.91)
7	Баянхутаг	96.70	297.54	200.84	90.47	103.83	13.36
8	Биндэр	151.56	240.55	88.99	77.38	122.10	44.72
9	Бор-Өндөр	339.26	335.65	(3.62)	242.04	227.29	(14.75)
10	Бэрх	11.23	13.35	2.12	226.43	236.70	10.27
11	Галшар	124.71	104.71	(20.00)	214.83	11.05	(203.78)
12	Гурванбаян	17.18	71.13	53.95	20.91	1.21	(19.70)
13	Дадал	46.29	209.44	163.15	36.62	190.94	154.32
14	Дархан	388.98	261.30	(127.68)	37.12	66.18	29.06
15	Дэлгэрхаан	97.32	53.93	(43.39)	78.11	89.41	11.30
16	Жаргалтхаан	0.07	50.80	50.73	149.63	147.17	(2.46)
17	Мөрөн	89.47	150.37	60.90	101.00	18.38	(82.61)
18	Норовлин	86.54	295.75	209.21	92.12	35.40	(56.72)
19	Өлзийт	18.34	85.93	67.58	5.92	5.92	-
20	Өмнөдэлгэр	795.61	861.19	65.58	52.56	98.13	45.58
21	Хэрлэнбаян-Улаан	87.90	70.53	(17.37)	8.86	9.86	1.00
22	Хэрлэн	248.59	299.67	51.08	318.56	43.31	(275.25)
23	Цэнхэрмандал	389.15	262.44	(126.71)	55.50	71.93	16.43
	ДҮН	3,855.38	5,407.85	1,552.47	2,491.31	2,262.59	(228.71)

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдлийн дийлэнх хувийг аймаг буюу Өмнөдэлгэр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл, Сум хөгжүүлэх сангийн үлдэгдлийн дийлэнх хувийг Баянмөнх, Бор-Өндөр, Бэрх, Баян-Адарга сумдын Сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

1. Тайлант онд 22 ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд замд яваа татварын орлогын 338.8 сая төгрөгийг тусгалгүй орхигдуулсан, Дэлгэрхаан сумын Аварга тохижилт ОНӨААТҮГ арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдлийг илүү тайлагнасан алдааг аудитын явцад залруулсан.

2. Анхан шатны баримтын бүрдэлгүй, албан тушаалтан, эд хариуцагч нарын хувийн харилцах дансаар дамжуулж мөнгө зарцуулсан, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй нийт 103.4 сая төгрөгийн 8 зөрчлийн 4.6 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 98.8 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 6 албан шаардлага хүргүүлсэн. Үүнээс сум, байгууллагыг дурдвал:

Төлбөрийн акт:

- Бор-Өндөр сумын ЗДТГ 3.4 сая төгрөг,
- Дархан тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ 1.2 сая төгрөг,

Албан шаардлага:

- Аймгийн ИТХ 46.5 сая төгрөг,
- Жаргалтхаан сумын ЗДТГ 2.3 сая төгрөг,
- Мөрөн сумын ЗДТГ 16.4 сая төгрөг,
- Цэнхэрмандал сумын ИТХ 2.0 сая төгрөг,
- Цэнхэрмандал сумын ЗДТГ 21.4 сая төгрөг,
- Өндөрхаан хот тохижилт ОНӨААТҮГ 11.1 сая төгрөг тус тус байна.

4.2 АВЛАГА

Авлага дансны үлдэгдэл 7,975.8 сая төгрөг болж, өмнөх оноос 511.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Авлагын дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	20.30	7.82	(12.48)	0%
Төлбөртэй үйлчилгээний авлага	130.30	136.59	6.29	2%
Зээлийн хүүгийн авлага	19.60	171.83	152.23	2%
Дансны авлага /ТӨҮГ/	297.70	447.41	149.71	6%
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	0.10	1.10	1.00	0%
Байгууллагаас авах авлага	1,115.40	881.02	(234.38)	11%
Хувь хүмүүсээс авах авлага	355.00	584.05	229.05	7%
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээл	30.00		(30.00)	0%
Хувь хүмүүст олгосон зээл	5,334.60	5,593.56	258.96	70%
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	161.60	152.40	(9.20)	2%
Дүн	7,464.60	7,975.78	511.18	100%
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>				
ОНӨҮГ	844.25	841.37	(2.88)	11%
Төрийн сан	30.00	-	(30.00)	0%
Төсөвт байгууллага	229.25	598.89	369.64	8%
Төсөл, сан	6,361.10	6,535.52	174.42	82%
Нийт дүн	7,464.60	7,975.78	511.18	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны нийт үлдэгдлийн дийлэнх буюу 70.0 хувийг хувь хүмүүст олгосон зээл, 11.0 хувийг байгууллагаас авах авлага, 7.0 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 6.0 хувийг ОНӨҮГ-ын дансны авлага, 2.0 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл, 2.0 хувийг төлбөртэй үйлчилгээний авлага эзэлж байна.

Тайлант онд төлбөртэй үйлчилгээний авлага 6.3 сая төгрөг, зээлийн хүүгийн авлага 152.2 сая төгрөг, дансны авлага 149.7 сая төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 229.0 сая төгрөг, хувь хүмүүст олгосон зээл 259.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Зээлийн хүүгийн авлага дансны үлдэгдэл 171.8 сая төгрөг болж өсөхөд сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зээлийн үлдэгдэл, хүүгийн авлагыг салгаж бүртгүүлсэн нөлөөлсөн байна.

Дансны авлагын үлдэгдэл 447.4 сая төгрөг болж 149.7 сая төгрөгөөр өссөн нь Хэнтий-Ус ХХК, Биндэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ, Батширээт Сум дундын ойн анги, Дархан Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хувь хүмүүсээс авах авлага дансны үлдэгдэл 584.1 сая төгрөг болж 229.1 сая төгрөгөөр өссөн нь Бор-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын шүүхийн шийдвэрээр авах авлагын 342.8 сая төгрөгөөр нэмэгджээ.

Хувь хүмүүсээс авах авлага буурахад Хэнтий орон сууц ОНӨААТҮГ-ын орон сууцны авлага 1,311.4 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Тайлант онд хувь хүмүүст олгосон зээл буюу хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 477.5 сая төгрөгөөр буурч, Баян-Овоо, Батноров, Бор-Өндөр, Галшар, Гурванбаян, Жаргалтхаан, Мөрөн, Норовлин, Хэрлэн суманд 916.1 сая төгрөгийн зээл олголтоор нэмэгдсэн байна.

Хүснэгт №6. Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл, сумаар /сая төгрөгөөр/

Сум, тосгоны нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Батноров	202.03	279.86	77.83	5%
Батширээт	248.01	198.76	(49.25)	3%
Баян-Адарга	202.18	80.13	(122.05)	1%
Баянмөнх	59.10	37.95	(21.15)	1%
Баян-Овоо	104.33	128.28	23.95	2%
Баянхутаг	202.75	189.70	(13.04)	3%
Биндэр	273.16	239.23	(33.92)	4%
Бор-Өндөр	705.18	741.80	36.62	13%
Бэрх	59.26	49.04	(10.22)	1%
Галшар	84.09	315.78	231.69	5%
Гурванбаян	21.21	58.02	36.81	1%
Дадал	278.10	133.83	(144.27)	2%
Дархан	292.24	284.21	(8.03)	5%
Дэлгэрхаан	250.25	238.80	(11.45)	4%
Жаргалтхаан	160.95	169.05	8.10	3%
Мөрөн	204.38	296.99	92.61	5%
Норовлин	220.80	277.58	56.78	5%
Өмнөдэлгэр	345.59	299.39	(46.20)	5%
Хэрлэн	1.00	-	(1.00)	0%
Хэрлэн	1,328.53	1,659.01	330.48	28%
Цэнхэрмандал	257.58	240.62	(16.97)	4%
Дүн	5,500.72	5,918.03	417.31	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийн дийлэнх хувийг Хэрлэн, Бор-Өндөр сумын сангийн үлдэгдэл эзэлж байна.

Зээлийн авлагыг насжилтаар авч үзвэл 2,341.2 сая төгрөгийн зээл 1-3 жилийн насжилттай, 636.2 сая төгрөгийн зээл 4-5 жилийн насжилттай, 2,170.6 сая төгрөгийн зээл 5-аас дээш жилийн насжилттай ба 5-аас дээш жилийн насжилттай хугацаа хэтэрсэн зээл нийт үлдэгдлийн 36.6 хувийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Авлага данстай холбоотой нийт 695.5 сая төгрөгийн 23 алдаа илэрснээс авлагыг тусгалгүй орхигдуулсан, ХХС-ийн зээлийн хүүгийн авлагыг зээлийн авлагаас тусад нь тайлагнаагүйг санхүүгийн тайланд залруулсан байна.

Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй 183.1 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 7 сумын ХХС-ийн 877.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах арга хэмжээ авах талаар 7 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

Албан шаардлага:

- Баян-Адарга сумын ЗДТГ 12.2 сая төгрөг,
- Бор-Өндөр ЗДТГ 9.0 сая төгрөг,
- Бор-Өндөр ОНХС 120.8 сая төгрөг,
- Хэрлэн сумын ЗДТГ 27.4 сая төгрөг,
- Норовлин ХХС 4.8 сая төгрөг,
- Биндэр Ой СДОА 8.8 сая төгрөг,

Зөвлөмж:

- Баян-Овоо сумын Засаг дарга 67.4 сая төгрөг,
- Баянмөнх сумын Засаг дарга 31.6 сая төгрөг,
- Баянхутаг сумын Засаг дарга 116.4 сая төгрөг,
- Дэлгэрхаан сумын Засаг дарга 238.8 сая төгрөг,
- Мөрөн сумын Засаг дарга 137.8 сая төгрөг,
- Өмнөдэлгэр сумын Засаг дарга 223.4 сая төгрөг,
- Баян-Овоо сумын Засаг дарга 67.4 сая төгрөг тус тус байна.

4.3 УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны үлдэгдэл 1,624.4 сая төгрөг болж, өмнөх оноос 672.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Урьдчилгаа дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Урьдчилж гарсан зардал	785.10	1,472.14	687.04	91%
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	165.75	151.75	(14.00)	9%
Цалингийн урьдчилгаа	1.29	0.54	(0.75)	0%
Дүн	952.14	1,624.43	672.29	100%
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>				
ОНӨҮГ	1.13	2.20	1.07	0%
Төсөвт байгууллага	299.34	652.36	353.02	40%
Төсөл, сан	651.67	969.87	318.20	60%
Дүн	952.14	1,624.43	672.29	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны нийт үлдэгдлийн 60.0 хувийг төсөл, сангийн, 40.0 хувийг төсөвт байгууллагын урьдчилгаа эзэлж байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл Баянмөнх, Биндэр, Галшар, Цэнхэрмандал сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнд урьдчилж төлсөн 690.1 сая төгрөгөөр нэмэгдэж, Баян-Адарга, Батширээт, Гурванбаян, Дархан сумын 371.9 сая төгрөгийн урьд онд урьдчилж төлсөн төсөл арга хэмжээ хэрэгжсэнээр буурсантай холбоотой байна

Аудитын илрүүлэлт:

1. Цалингийн урьдчилгааг суутгахдаа дансны бичилт буруу хийсэн, урьдчилж гарсан зардлыг зардалд хаасан нийт 92.5 сая төгрөгийн 7 алдааг санхүүгийн тайланд залруулсан байна. Үүнд:

- Баян-Овоо сумын ЗДТГ 7.0 сая төгрөг,
- Биндэр сумын ЗДТГ 5.0 сая төгрөг,
- Бор-Өндөр сумын ЗДТГ 8.0 сая төгрөг,
- Дадал сумын ЗДТГ 10.0 сая төгрөг,
- Мөрөн сумын ЗДТГ 49.5 сая төгрөг,

- Цэнхэрмандал сумын ЗДТГ 7.5 сая төгрөг,
 - Өмнөдэлгэр сумын ОНХС 5.5 сая төгрөг тус тус байна.
2. Хэнтий орон сууц ОНӨААТҮГ -ын 0.7 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон байна.

4.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын үлдэгдэл 10,416.1 сая төгрөг болж, өмнөх оноос 1,100.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8. Бараа материал данс ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалттай материал	179.19	214.91	35.72	2%
Эм боох материал	99.38	104.86	5.48	1%
Дуусаагүй үйлдвэрлэл	37.01	-	(37.01)	0%
Бэлэн бүтээгдэхүүн	1.76	5.56	3.80	0%
Бичиг хэргийн материал	162.98	284.75	121.77	3%
Аж ахуйн материал	3,115.98	3,540.82	424.84	34%
Сэлбэг хэрэгсэл	158.98	190.45	31.47	2%
Түлш, шатах тослох материал	44.08	82.45	38.37	1%
Барилгын засварын материал	119.26	108.51	(10.75)	1%
Хүнсний материал	0.29	-	(0.29)	0%
Бусад хангамжийн материал	4,811.99	5,222.81	410.82	50%
Биологийн хөрөнгө	17.70	17.70	-	0%
Мал амьтад	566.92	643.24	76.32	6%
Дүн	9,315.52	10,416.06	1,100.54	100%
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>			-	-
ОНӨҮГ	1,183.19	1,619.48	436.29	16%
Төсөвт байгууллага	8,132.33	8,796.58	664.25	84%
Дүн	9,315.52	10,416.06	1,100.54	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 50 хувийг бусад хангамжийн материал, 34 хувийг аж ахуйн материал, 6 хувийг мал амьтад эзэлж байна.

Аж ахуйн материалын дансны үлдэгдэл 424.8 сая төгрөгөөр өссөн нь сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газрын материал 518.7 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бусад хангамжийн материал дансны үлдэгдэлд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн тайлант онд дуусаагүй төсөл арга хэмжээний 1,034.3 сая төгрөг, Норовлин, Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын материал 167.0 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

1. Бор-Өндөр сумын ИТХ нь 4.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

2. Нийт 167.0 сая төгрөгийн 11 зөрчил илэрснээс анхан шатны баримтын бүрдэлгүй бараа материал зарцуулсан 7.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэргүй бараа материалыг данснаас хассан, бараа материалын тайлан гаргаагүй, үлдээдгийг тоолж, тооцоо бодож баталгаажуулаагүй 159.2 сая төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнээс:

Төлбөрийн акт:

- Баян-Овоо сумын ЗДТГ 4.9 сая төгрөг,
- Өндөрхаан хот тохижилт ОНӨААТҮГ 2.9 сая төгрөг,

Албан шаардлага:

- Мөрөн сумын ЗДТГ 7.1 сая төгрөг,
- Хэрлэн сумын ЗДТГ 6.5 сая төгрөг,
- Тахилгат тосгоны ЗАА 3.9 сая төгрөг,
- Өмнөдэлгэр сумын ИТХ 2.3 сая төгрөг,
- Өмнөдэлгэр сумын Нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ 49.9 сая төгрөг,
- Цэнхэрмандал сумын ЗДТГ 55.6 мянган төгрөг,
- Хэнтий -Ус ХХК 33.8 сая төгрөг тус тус байна.

НӨӨЦИЙН БАРАА

Нөөцийн бараа дансны үлдэгдэл 379.5 сая төгрөг болж, өмнөх оноос 135.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9. Нөөцийн бараа дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тэжээлийн нөөц	236.95	379.46	142.51	100%
Шатахууны нөөц	7.00	-	(7.00)	0%
Дүн	243.95	379.46	135.51	100%
Үүнээс: байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	243.95	379.46	135.51	100%
Дүн	243.95	379.46	135.51	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нөөцийн барааны үлдэгдэлд 12 сумын ЗДТГ-ын 304.3 сая төгрөг, малын эрсдэлээс хамгаалах сангийн 75.2 сая төгрөгийн өвс, тэжээл, хивэг будааны нөөц байна.

Аудитын илрүүлэлт:

Нөөцийн бараа данстай холбоотой нийт 57.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 41.6 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 15.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

Төлбөрийн акт:

- Баянмөнх сумын ЗДТГ 7.0 сая төгрөгийн нөөцийн тэжээл борлуулж орлогыг төсөвт төвлөрүүлээгүй,
- Мөрөн сумын ЗДТГ 34.6 сая төгрөгийн өвс, тэжээлийг анхан шатны баримтгүй зарлагадсан байна.

Албан шаардлага:

-Жаргалтхаан сумын ЗДТГ нөөцийн барааны 1.5 сая төгрөгийн үлдээдгийг тоолоогүй, тайлан гаргаагүй, 14.0 сая төгрөгийн зарлага гарсан боловч нотлох баримтгүй байна.

4.5 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт №10. Бусад эргэлтийн хөрөнгийн данс байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ОНӨҮГ	203.13	203.13	-	100.0
Дүн	203.13	203.13	-	100.0

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэлд Хэнтий орон сууц ОНӨААТҮГ-ын эзэмшилд байгаа борлуулах зорилготой орон сууцны зоорийн давхрын байр бүртгэлтэй байна.

4.6 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл цэвэр дүнгээр 251,023.3 сая төгрөг болж, өмнөх оноос 51,472.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №11. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Биет хөрөнгө	180,134.76	237,407.37	57,272.61	95%
Биет бус хөрөнгө	19,415.66	13,615.97	(5,799.69)	5%
Дүн	199,550.42	251,023.34	51,472.92	100%
<i>Үүнээс: байгууллагын төрлөөр</i>				
ОНӨҮГ	83,457.68	131,606.60	48,148.92	52%
Төсөвт байгууллага	116,089.44	119,413.67	3,324.23	48%
Төсөл, сан	3.30	3.07	(0.23)	0%
Дүн	199,550.42	251,023.34	51,472.92	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 51,472.9 сая төгрөгөөр өссөн нь барилга, байгууламж 8,309.5 сая төгрөг, авто тээврийн хэрэгсэл 2,817.3 сая төгрөг, машин тоног төхөөрөмж 44,618.8 сая төгрөг, зам, гүүрийн байгууламж 4,469.1 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 8,314.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой байна.

Барилга байгууламж дансны үлдэгдэл өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, Бэрхийн дулааны станцын барилга, Хэрлэн суманд хийгдсэн цэвэр, бохир усны шугам сүлжээг Хэнтий-Ус ХХК-д, Дадал суманд баригдсан Хог боловсруулах үйлдвэрийг Засаг даргын тамгын газарт, Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хорооллын дундах тоглоомын талбай, байрны гадна тохижилт, авто машины зогсоол, гэрэлтүүлэг зэрэг хөрөнгийг Өндөрхаан тохижилт ОНӨААТҮГ-т бүртгэсэнтэй холбоотой байна.

Авто тээврийн хэрэгсэл дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн хөрөнгө оруулалт, сумын орон нутгийн хөгжлийн сангаас худалдан авсан 7 ширхэг автомашин, ковшийг Өндөрхаан тохижилт ОНӨААТҮГ-т, орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан авто машиныг Өмнөдэлгэр сумын ЗДТГ-т, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан тусгай зориулалтын авто автомашиныг Жаргалтхаан сумын ЗДТГ-т бүртгэсэнтэй холбоотой байна.

Машин тоног төхөөрөмжийн дансны үлдэгдэл өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн Бэрхийн дулааны станцын тоног төхөөрөмжийг Хэнтий-Ус ХХК-д, орон нутгийн хөрөнгө оруулалт, сумын орон нутгийн хөгжлийн сангаас бэлтгэсэн тоног төхөөрөмжийг Өндөрхаан хот тохижилт ОНӨААТҮГ-т бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

Зам гүүрийн барилга дансны өсөлт орон нутгийн хөгжлийн сангаас бэлтгэсэн талбай, замын гэрэлтүүлэг, замын тэмдэг тэмдэглэгээ, замын хашлага, хурд сааруулагч, камержуулалт, зам гүүрийн засвар Батширээт, Баянмөнх, Бор-Өндөр, Цэнхэрмандал сумын ЗДТГ, Бэрх хөгжил, Өндөрхаан хот тохижилт ОНӨААТҮГ-т бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

1. ТТЗ-дийн харьяа байгууллагуудын тайланд ОНХС болон бусад эх үүсвэрээр бэлтгэгдсэн хөрөнгийг орлого аваагүй, элэгдлийг илүү, дутуу бүртгэсэн, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхөж үлдэх өртөггүй болсон хөрөнгийг дахин үнэлж бүртгэхдээ дахин үнэлгээний нэмэгдэл дансыг нэмэгдүүлсэн нийт 2,726.6 сая төгрөгийн 35 алдааг санхүүгийн тайланд аудитын явцад залруулсан. Үүнээс томоохон дүнтэй сум, байгууллагыг дурдвал:

- Баян-Адарга сумын ЗДТГ 54.5 сая төгрөг,
- Батширээт сумын ЗДТГ 80.0 сая төгрөг,
- Баян-Овоо сумын ЗДТГ 567.0 сая төгрөг,
- Биндэр сумын ЗДТГ 313.5 сая төгрөг,
- Бор-Өндөр сумын ЗДТГ 93.0 сая төгрөг,
- Бэрх сумын ЗДТГ 191.7 сая төгрөг,
- Гурванбаян тосгоны ЗАА 197.4 сая төгрөг,
- Мөрөн сумын ЗДТГ 87.9 сая төгрөг,
- Цэнхэрмандал сумын ЗДТГ 471.3 сая төгрөг,
- Дэлгэрхаан сумын Аварга тохижилт ОНӨААТҮГ 328.0 сая төгрөг,
- Хэнтий -Ус ХХК 65.8 сая төгрөг

2. Нийт 386.0 сая төгрөгийн 7 зөрчлийн илэрснээс 3 зөрчилд албан шаардлага, 4 зөвлөмж өгсөн байна. Үүнд:

Албан шаардлага:

-Тахилгат тосгоны ЗАА 37.9 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг ОНӨГ-ын шийдвэргүй, ашиглалтын гэрээ байгуулалгүй ашиглуулсан.

-Цэнхэрмандал сумын ЗДТГ тайлант оны эцэст 233.3 сая төгрөгийн тоног, төхөөрөмжийн үлдэгдлийг тоолж, баталгаажуулаагүй.

-Хэнтий орон сууц ОНӨААТҮГ Хэрлэн сумын "Шинэ Өндөрхаан" хороололд баригдсан 48 айлын орон сууцны гүйцэтгэгч "Алсын солонго" ХХК-тай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд бий болсон 114.8 сая төгрөгийн 41 м2 2 өрөө байрыг үндсэн хөрөнгөд бүртгэх, гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулаагүй.

4.7 ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 83,408.7 сая төгрөг болж, өмнөх оноос 41,271.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №12. Өр төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат зээлийн өглөг	221.80	163.14	(58.66)	0%
Өглөг	9,353.33	6,043.03	(3,310.30)	7%
Урьдчилж орсон орлого	20,141.46	65,014.71	44,873.25	78%
Урт хугацаат өр төлбөр	12,421.05	12,187.80	(233.25)	15%
Дүн	42,137.64	83,408.68	41,271.04	100%
Үүнээс: байгууллагын төрлөөр				
ОНӨҮГ	42,091.28	80,739.51	38,648.23	97%
Төсөвт байгууллага	10.71	679.21	668.50	1%

Төсөл, сан	35.65	1,989.96	1,954.31	2%
Нийт дүн	42,137.64	83,408.68	41,271.04	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн үлдэгдлийн 78.0 хувийг урьдчилж орсон орлого, 15.0 хувийг урт хугацаат зээл, 7.0 хувийг бусад өглөг эзэлж байна.

Урьдчилж орсон орлогын үлдэгдэлд Хэнтий-Ус ХХК, Биндэр, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сумын Ойн анги, Бэрх, Биндэр, Дархан, Дэлгэрхаан сумын орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийг бүртгэсэн байна.

Уг хөрөнгийн 57,304.2 сая төгрөг буюу 88.0 хувийг Хэнтий-Ус ХХК, 5,832.1 сая төгрөг буюу 9.0 хувийг Бэрх хөгжил ОНӨААТҮГ, 1.0 хувийг Дархан сумын Төхижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын хөрөнгө эзэлж байна.

Богино хугацаат зээлийн үлдэгдлийн 163.1 сая төгрөг нь Хэнтий-Ус ХХК-ийн ногоон зээлийн үлдэгдэл ба зээл хуваарийн дагуу хугацаандаа төлөгдөж байна.

Урт хугацаат өр төлбөрийн 12,187.8 сая төгрөгийн үлдэгдэл нь Хэнтий-Ус ХХК-ийн МОН-1907 Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн 2 дугаар үе шатны төслийн хүрээнд 2003 онд авсан 1,975.2 сая төгрөг, МОН-3713 Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд 2019 онд авсан 2.9 сая ам долларын зээл байна.

Тус зээлийн төлбөрт 2022 онд 799.6 сая төгрөг, 2023 онд 725.7 сая төгрөг, 2024 онд 536.2 сая төгрөг, 2025 онд 1,000.0 сая төгрөг нийт 3,061.5 сая төгрөгийг төлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

1. Өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй, илүү, дутуу тусган илэрхийлсэн 1,369.4 сая төгрөгийн 7, ОНӨААТҮГ-ууд урьдчилж орсон орлогыг тайлант хугацааны элэгдлийн зардлын дүнгээр бууруулах бичилт хийгээгүй, урьдчилж орсон орлогыг өмнөх оны үр дүнд хаасан 6,878.1 сая төгрөгийн 4 алдаа, нийт 8,247.5 сая төгрөгийн 11 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан байна. Үүнээс залруулсан алдаанд гол нөлөөлсөн сум, байгууллагыг дурдвал:

Өглөг.

- Дэлгэрхаан сумын ОНХС 109.0 сая төгрөг,
- Жаргалтхаан сумын ОНХС 46.1 сая төгрөг,
- Хэнтий -Ус ХХК 1,204.2 сая төгрөг,

Урьдчилж орсон орлого:

- Биндэр Ой СДОА 25.5 сая төгрөг,
- Бэрх хөгжил ОНӨААТҮГ 6,637.4 сая төгрөг,
- Хэнтий Ус ХХК 215.1 сая төгрөг тус тус байна.

2. Жаргалтхаан сумын ОНХС-ийн 46.1 сая төгрөгийн өглөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

4.8 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 221,252.9 сая төгрөг болж, өмнөх оноос 8,333.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №13. Засгийн газрын хувь оролцоо дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	32,579.63	32,664.06	84.43	15%
Өмч /ОНӨҮГ/	2,022.06	2,066.15	44.09	1%
Өмнөх үеийн үр дүн	138,999.46	162,852.93	23,853.47	74%
Тайлант оны үр дүн	23,913.51	8,325.34	(15,588.17)	4%
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,404.55	15,344.40	(60.15)	7%
Дүн	212,919.21	221,252.88	8,333.67	100%

Эх сурвалж: Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 3,673.6 сая төгрөг, төсөвт байгууллагын 3,634.4 сая төгрөг, төрийн сангийн 884.0 сая төгрөг, төсөл сангийн 141.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын сан нь Дадал, Дархан, Дэлгэрхаан сумын ЗДТГ, Оюуны шим ӨЭМТ-ийн газрыг бүртгэсэнтэй холбоотой 84.4 сая төгрөгөөр, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч Баян-Адарга сумын Хатдын өргөө ОНӨҮГ, Адарга тохижилт ОНӨҮГ, Хэнтий Орон сууц ОНӨҮГ-ын 44.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

4.9 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитад аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлсэн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 22, орон нутгийн төсвийн 48, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 22, тусгай сан 46 нийт 138 санхүүгийн тайланг аудитад хамруулж, 53 санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 85 санхүүгийн тайланд үе шатны ажлын хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Нийт дүгнэлт өгсөн байгууллагаас 19 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 33 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт өгсөн байна.

Хүснэгт №14. “Сөрөг”, “Хязгаарлалттай” дүгнэлтийг төсөө захирагчаар харуулбал

№	Байгууллагын нэр	Дүгнэлт	№	Байгууллагын нэр	Дүгнэлт
1	Цэнхэрмандал ЗД	Сөрөг	18	Гурванбаян Захирагч	Хязгаарлалттай
2	Баянхутаг ЗД	Хязгаарлалттай	19	Өлзийт Захирагч	Хязгаарлалттай
3	Баян-Адарга ЗД	Хязгаарлалттай	20	Аймгийн ИТХ	Хязгаарлалттай
4	Баян-Овоо ЗД	Хязгаарлалттай	21	Баян-Адарга ЗДТГ	Хязгаарлалттай
5	Баянмөнх ЗД	Хязгаарлалттай	22	Баян-Овоо ЗДТГ	Хязгаарлалттай
6	Батширээт ЗД	Хязгаарлалттай	23	Баянмөнх ЗДТГ	Хязгаарлалттай
7	Биндэр ЗД	Хязгаарлалттай	24	Батширээт ЗДТГ	Хязгаарлалттай
8	Бор-Өндөр ЗД	Хязгаарлалттай	25	Бор-Өндөр ЗДТГ	Хязгаарлалттай
9	Галшар ЗД	Хязгаарлалттай	26	Галшар ЗДТГ	Хязгаарлалттай
10	Дархан ЗД	Хязгаарлалттай	27	Жаргалтхаан ЗДТГ	Хязгаарлалттай
11	Дадал ЗД	Хязгаарлалттай	28	Цэнхэрмандал ЗДТГ	Хязгаарлалттай
12	Дэлгэрхаан ЗД	Хязгаарлалттай	29	Гурванбаян ЗАА	Хязгаарлалттай
13	Мөрөн ЗД	Хязгаарлалттай	30	Мөрөн ЗДТГ	Хязгаарлалттай
14	Норовлин ЗД	Хязгаарлалттай	31	Тахилгат ЗАА	Хязгаарлалттай
15	Өмнөдэлгэр ЗД	Хязгаарлалттай	32	Өлзийт ЗАА	Хязгаарлалттай
16	Жаргалтхаан ЗД	Хязгаарлалттай	33	Хэрлэн ЗДТГ	Хязгаарлалттай
17	Хэрлэн ЗД	Хязгаарлалттай	34	Өндөрхаан хот тохижилт ОНӨААТҮГ	Хязгаарлалттай

Эх сурвалж: ТШЗ, ТТЗ, ОНӨҮГ-ын 2025 оны санхүүгийн аудитлагдсан тайлан

Аудитаар нийт 21,785.0 сая төгрөгийн 163 алдааг аудитын явцад залруулж, 1,994.6 сая төгрөгийн 56 зөрчил илэрснээс 54,7 сая төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 1,049,5 сая төгрөгийн зөрчилд 32 албан шаардлага хүргүүлж, 877.4 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өгч, 13.1 сая төгрөгийн зөрчилд 5 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, гэмт хэргийн шинжтэй 1 асуудлыг Прокурорын байгууллагад шилжүүлсэн байна.

4.10 ӨМНӨХ ОНЫ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Засаг даргад 381.7 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага, 4 зөвлөмж хүргүүлснээс орон сууцны зээлийн сан, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас олгосон зээлийн үлдэгдлийн хуваарийн дагуу төлөгдөхгүй байгаа зээлдэгчийг холбогдох газраар шийдвэрлүүлэх, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийг дээшлүүлэх, хариуцлагын хэлбэрийг оновчтой тодорхойлох ажлыг үе шаттайгаа зохион байгуулж байна.

Мөн малын эрсдэлийн сангийн үлдэгдэл өвс, тэжээлийг жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор тоолж, тооцоо бодсон, урт хугацаат дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөлтийг 2025 онд 1,000.0 сая төгрөгөөр төлж, 2026 онд 2,170.0 сая төгрөгөөр төлөхөөр төлөвлөн ажиллаж байна

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь тайлант хугацааны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийж, эрсдэлийг удирдаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулаагүй байна.

Хүснэгт 15: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	-	-	-	-	-	-	0%
Албан шаардлага	2	381.71	2	381.71	-	-	100%
Зөвлөмж	3	-	2	-	1	-	33%
Нийт	5	381.71	4	381.71	1	-	66%

4. 11 ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахад Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын үйл ажиллагааг чиглүүлэн эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллах зөвлөмжийг Засаг даргад өгсөн боловч уг зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Дотоод аудитын хорооны хуралдаанаар 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар илэрсэн зөрчлийн шийдвэрлэлтийг 2026 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр хэлэлцэн 01, 02, 03, 04-р тогтоолоор баталсан байна.

Тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 4-т “Сангийн яам нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд баримтын иж бүрэн шалгалтыг 2 жил тутам нэгээс доошгүй удаа заавал хийх ба шалгалтын дүнг хамтран хэлэлцэж шаардлагатай арга хэмжээ авна.” гэснийг үндэслэн санхүүгийн хяналт шалгалтыг өнгөрсөн 2023, 2024 оны санхүүгийн баримтад хийж байна.

Энэ нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн 2.1-д “Дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэсэн зорилгыг хангахгүй байна.

5. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 718.3 сая төгрөгийн 6 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн тайлант оны зээл төлөлтийн 500.0 мянган төгрөгийн орлогыг дутуу бүртгэсэн.
- Бор-Өндөр сумын Бор-Өндөр хот тохижилтын нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийн авлагын устгах бичилтийг төсөвт байгууллагын өөрийн орлого дансанд бүртгэсэн.
- Дархан сумын Байгаль хамгаалах сангийн 19,5 сая төгрөг, Бэрх тосгоны Захирагчийн ажлын албаны Ахмадын сангийн 2.0 сая төгрөг, аймгийн Санхүүгийн хяналт, аудитын газрын Ахмадын сангийн 4,0 сая төгрөг нийт 25.5 сая төгрөгийн орлогыг үндсэн үйл ажиллагааны орлого дансанд бүртгэсэн байна.
- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал 10.0 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлыг дутуу, Засаг даргын тамгын газар хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг 57.6 сая төгрөгөөр аудитлагдсан тайлангаас илүү дүнгээр тайланд нэгтгүүлсэн.
- Баян-Адарга сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 3.6 сая төгрөгийн орлогыг бусад орлого дансанд бүртгэсэн.
- Бор-Өндөр сумын Цэгцүүлэн дом ӨЭМТ нь санхүүжилтийн орлогыг татаас, санхүүжилтийн орлого /ТӨҮГ/ дансанд бүртгэж устгах бичилтийг хийсэн.

Аудитаар өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

5.1 АЛБАН ШААРДЛАГА

Өмнөх оны аудитаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахад Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын үйл ажиллагааг чиглүүлэн эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

5.2 ҮАГ-Т ӨГӨХ САНАЛ

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 2.1-д заасан зорилгод “эрсдэлийг урьдчилан тодорхойлж, түүнээс сэргийлэх арга хэмжээ авч ажиллах” гэж нэмэлт өөрчлөлт оруулах замаар алдаа зөрчлийг бууруулах.

6 АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хэнтий аймгийн ИТХ	2	16.89		-	2	16.89	2	16.89				
Хэнтий аймгийн ОНХС	1	400.08	1	400.08		-	1	400.08				
Батноров ЗД	1	62.93	1	62.93		-	1	62.93				
Батноров ЗДТГ	2	9.96		-	2	9.96	2	9.96				
Батноров ХХС	1	6.58		-	1	6.58	1	6.58				
Батноров ОНХС	1	27.01		-	1	27.01	1	27.01				
Батширээт ЗД	1	22.01	1	22.01		-	1	22.01				
Батширээт ЗДТГ	2	85.44	1	5.44	1	80.00	2	85.44				
Баян-Адарга ЗД	2	4,982.64	2	4,982.64		-	2	4,982.64				
Баян-Адарга ЗДТГ	2	59.05	1	4.53	1	54.52	2	59.05				
Баян-Адарга ХХС	1	7.71	1	7.71		-	1	7.71				
Баян-Адарга ОНХС	1	4.53		-	1	4.53	1	4.53				
Баянмөнх ЗД	1	2.15	1	2.15		-	1	2.15				
Баянмөнх ИТХ	1	2.16	1	2.16		-	1	2.16				
Баянмөнх ЗДТГ	2	26.04		-	2	26.04	2	26.04				
Баянмөнх ХХС	1	5.18		-	1	5.18	1	5.18				
Баянмөнх ОНХС	1	20.95	1	20.95		-	1	20.95				
Баян-Овоо ЗД	1	1.96	1	1.96		-	1	1.96				
Баян-Овоо ИТХ	1	0.93		-	1	0.93	1	0.93				
Баян-Овоо ЗДТГ	5	584.88	1	101.27	4	483.62	5	584.88				
Баян-Овоо ХХС	1	0.68		-	1	0.68	1	0.68				
Баян-Овоо ОНХС	1	76.99		-	1	76.99	1	76.99				
Баянхутаг ЗД	2	403.95	1	6.34	1	397.61	2	403.95				
Баянхутаг ЗДТГ	4	88.08	1	34.00	3	54.08	4	88.08				
Баянхутаг ХХС	1	5.55		-	1	5.55	1	5.55				
Баянхутаг ОНХС	1	26.49		-	1	26.49	1	26.49				
Биндэр ЗД	2	10.52	1	6.60	1	3.91	2	10.52				
Биндэр ЗДТГ	7	632.20	1	145.92	6	486.27	7	632.20				
Биндэр ХХС	1	6.55		-	1	6.55	1	6.55				
Биндэр Ой СДОА	3	39.90	2	14.41	1	25.49	3	39.90				
Бор-Өндөр ЗД	1	15.47	1	15.47		-	1	15.47				
Бор-Өндөр ИТХ	1	4.71		-	1	4.71	1	4.71				
Бор-Өндөр ЗДТГ	4	161.51	4	161.51		-	4	161.51				
Бор-Өндөр ХХС	2	6.37		-	2	6.37	2	6.37				
Бор-Өндөр ОНХС	1	21.67		-	1	21.67	1	21.67				
Бэрх ЗД	1	10.84	1	10.84		-	1	10.84				
Бэрх ЗАА	1	191.68		-	1	191.68	1	191.68				
Бэрх ОНХС	1	10.12		-	1	10.12	1	10.12				
Бэрх хөгжил	3	6,643.08		-	3	6,643.08	3	6,643.08				
Галшар ЗД	1	2.15	1	2.15		-	1	2.15				
Галшар ХХС	1	26.68		-	1	26.68	1	26.68				
Галшар ОНХС	1	18.08		-	1	18.08	1	18.08				
Гурванбаян Захирагч	1	2.68	1	2.68		-	1	2.68				
Гурванбаян ЗАА	2	225.59		-	2	225.59	2	225.59				
Гурванбаян ХХС	1	2.14		-	1	2.14	1	2.14				
Гурванбаян ОНХС	1	150.44		-	1	150.44	1	150.44				
Дадал ЗД	1	9.96	1	9.96		-	1	9.96				
Дадал ЗДТГ	3	25.58	3	25.58		-	3	25.58				
Дадал ОНХС	2	137.32		-	2	137.32	2	137.32				
Дархан ЗД	2	6.14	1	4.34	1	1.80	2	6.14				
Дархан ЗДТГ	1	17.64		-	1	17.64	1	17.64				
Дархан ХХС	1	11.81		-	1	11.81	1	11.81				
Дархан Тохижилт үйлчилгээний газар	1	0.31	1	0.31		-	1	0.31				
Дэлгэрхаан ЗД	1	4.53	1	4.53		-	1	4.53				
Дэлгэрхаан ИТХ	1	7.27		-	1	7.27	1	7.27				
Дэлгэрхаан ЗДТГ	2	66.56		-	2	66.56	2	66.56				
Дэлгэрхаан ХХС	2	23.21		-	2	23.21	2	23.21				
Дэлгэрхаан ОНХС	2	131.89	1	109.04	1	22.86	2	131.89				
Дэлгэрхаан Аварга тохижилт	5	336.84	2	328.54	3	8.30	5	336.84				
Жаргалтхаан ЗД	1	3.78	1	3.78		-	1	3.78				
Жаргалтхаан ЗДТГ	1	5.33		-	1	5.33	1	5.33				

Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Жаргалтхаан ХХС	2	10.78		-	2	10.78	2	10.78				
Жаргалтхаан ОНХС	1	46.12	1	46.12		-	1	46.12				
Мөрөн ЗД	2	97.83	2	97.83		-	2	97.83				
Мөрөн ЗДТГ	4	187.72	2	88.43	2	99.30	4	187.72				
Мөрөн ХХС	1	114.30	1	114.30		-	1	114.30				
Норовлин ЗД	1	11.11	1	11.11		-	1	11.11				
Норовлин ЗДТГ	1	6.62		-	1	6.62	1	6.62				
Норовлин ОНХС	1	107.59		-	1	107.59	1	107.59				
Өлзийт Захирагч	1	50.24	1	50.24		-	1	50.24				
Өмнөдөлгөр ЗД	2	12.54	1	8.50	1	4.03	2	12.54				
Өмнөдөлгөр ЗДТГ	4	42.48		-	4	42.48	4	42.48				
Өмнөдөлгөр ХХС	2	2.62		-	2	2.62	2	2.62				
Өмнөдөлгөр ОНХС	1	5.50		-	1	5.50	1	5.50				
Өлзийт ОНХС	1	9.02		-	1	9.02	1	9.02				
Худалдан авах ажиллагааны газар	1	5.14		-	1	5.14	1	5.14				
Тахилагат тосгоны ЗАА	2	4.67		-	2	4.67	2	4.67				
Хэрлэнбаян-Улаан ЗАА	1	34.70		-	1	34.70	1	34.70				
Хэрлэнбаян-Улаан Захирагч	1	0.30	1	0.30		-	1	0.30				
Цэнхэрмандал ЗД	2	339.85	1	8.18	1	331.67	2	339.85				
Цэнхэрмандал ИТХ	1	0.44		-	1	0.44	1	0.44				
Цэнхэрмандал ЗДТГ	4	482.37		-	4	482.37	4	482.37				
Цэнхэрмандал ХХС	1	16.78		-	1	16.78	1	16.78				
Цэнхэрмандал ОНХС	2	842.59		-	2	842.59	2	842.59				
Хэрлэн сум ЗД	1	98.01	1	98.01		-	1	98.01				
Хэрлэн сум ХХС	1	34.84		-	1	34.84	1	34.84				
БОГ	1	1.80		-	1	1.80	1	1.80				
ОНӨГ	1	0.05		-	1	0.05	1	0.05				
СХДАГ	2	2.89		-	2	2.89	2	2.89				
Халамжийн сан ОН	1	179.59		-	1	179.59	1	179.59				
Ач манал ӨЭМТ	1	35.81	1	35.81		-	1	35.81				
Оюуны шим ӨЭМТ	3	611.98		-	3	611.98	3	611.98				
Хэрлэн дом ӨЭМТ	2	461.82		-	2	461.82	2	461.82				
Өндөрхаан хот тохижилт	1	31.82		-	1	31.82	1	31.82				
Хэнтий Орон сууц	1	7.90		-	1	7.90	1	7.90				
Хэнтий-Ус ХХК	6	1,983.93	2	1,466.75	4	517.18	6	1,983.93				
Цэгцүүлэн дом	1	1.91		-	1	1.91	1	1.91				
Хэнтий аймгийн Засаг дарга	6	718.34			6	718.34	6	718.34				
Дүн	169	22,503.36	53	8,525.39	116	13,977.97	169	22,503.36	-	-	-	-

6.2 ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хэнтий аймгийн Засаг дарга	1	-		-	1	-		-		-		
Хэнтий аймгийн ИТХ	2	45.61		-	1	45.61		-	1	-		
Хэнтий аймгийн ЗДТГ	1	-		-		-	1	-		-		
Хэрлэн сумын ЗДТГ	4	33.95		-	4	33.95		-		-		
Хэрлэн аймгийн Өндөрхаан Хот тохижилт	2	14.01	1	2.94	1	11.07		-		-		
Хэнтий орон сууц ОНӨАТҮГ	2	115.49	1	0.69	1	114.80		-		-		
Батширээт сум тохижилт	1	141.49		-	1	141.49		-		-		
Баян-Адрага сумын ЗДТГ	2	12.24		-	1	12.24	1	-		-		
Баянмөнх сумын Засаг дарга	1	31.59		-		-	1	31.59		-		
Баянмөнх сумын ЗДТГ	1	6.99	1	6.99		-		-		-		
Баян-Овоо сумын Засаг дарга	1	67.45		-		-	1	67.45		-		
Баян-Овоо сумын ЗДТГ	2	11.06	1	4.90	1	6.16		-		-		
Баянхутаг сумын Засаг дарга	1	116.41		-		-	1	116.41		-		
Биндэр сумын ЗДТГ	1	-		-	1	-		-		-		
Биндэр Ой СДОА	1	8.83		-	1	8.83		-		-		
Бор-Өндөр сумын ЗДТГ	3	16.82	1	3.37	2	13.45		-		-		
Бор-Өндөр сумын ОНХС	1	120.81		-	1	120.81		-		-		
Галшар сумын ИТХ	2	15.79		-	1	2.71		-	1	13.08		
Галшар сумын ЗДТГ	1	-		-		-	1	-		-		
Дархан тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	1	1.22	1	1.22		-		-		-		
Дэлгэрхаан сумын Засаг дарга	1	238.80		-		-	1	238.80		-		
Мөрөн сумын Засаг дарга	1	137.81		-		-	1	137.81		-		
Мөрөн сумын ЗДТГ	5	58.15	1	34.58	2	23.57		-	2	-		
Жаргалтхаан сумын ЗДТГ	2	17.80		-	2	17.80		-		-		
Жаргалтхаан сумын ОНХС	1	46.12		-	1	46.12		-		-		

Норовлин сумын ХХС	1	4.82		-	1	4.82		-		-		
Өмнөдэлгэр сумын Засаг дарга	1	223.40		-		-	1	223.40		-		
Өмнөдэлгэр сумын ИТХ	1	2.33		-	1	2.33		-		-		
Өмнөдэлгэр Нийтлэг үйлчилгээ	1	49.87		-	1	49.87		-		-		
Тахилгат тосгоны ЗАА	2	41.84		-	2	41.84		-		-		
Цэнхэрмандал сумын Засаг дарга	2	61.92		-		-	1	61.92	1	-		
Цэнхэрмандал сумын ИТХ	2	2.02		-	1	2.02	1	-		-		
Цэнхэрмандал сумын ЗДТГ	4	316.17		-	4	316.17		-		-		
Цэнхэрманд сумын ХХС	1										1	
Хэнтий Ус ХХК	1	33.80		-	1	33.80		-		-		
Дүн	57	1,994.62	7	54.69	33	1,049.46	11	877.39	5	13.08	1	-



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 20

Дугаар 298-А/2370448

Чингис хот

ХЭА-2026/001/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитаар Хэнтий аймгийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахад Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын үйл ажиллагааг чиглүүлэн эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ." гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьдаггүй, эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй байгаа зөрчлийг арилган, биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Аюурбунь)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.АРИНАА